



# **БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 1/70

Улаанбаатар хот

## Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9.8 дахь хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.4.1 дэх заалт, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 2.7, 3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

## Дэд хорооны дарга:

Д.Болормаа Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хот байгуулалтын газрын Инновац, технологи, төсөл хөтөлбөр хариуцсан ахлах шинжээч

## Нарийн бичгийн дарга:

Б.Мөнхбаяр Төрийн захиргааны удирдлагын газрын Статистик мэдээлэл, технологийн хэлтсийн Салбарын суурь судалгаа, статистикийн мэдээлэл хариуцсан щинжээч

Гишууд:

Х.Ган-Очир Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын  
дарга

Д.Бэлэгсайхан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хот байгуулалтын газрын Хот байгуулалтын хэлтсийн даргын албан ўургийг түр орлон гүйцэтгэгч

Ц.Ууганбаяр Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан шинжээч

Д.Гэрэлмаа Төрийн захиргааны удирдлагын газрын Өргөдөл  
гомдол, шагнал, дотоод ажил хариуцсан шинжээч

Г.Гантер Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн салбарын эрх зүйн зохицуулалт хариуцсан шинжээч

152420714

2. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон холбогдох дүрэм, журамд заасан эрх, чиг үүргийг хэрэгжүүлж, биелэлтийг тайлагнаж ажиллахыг Ёс зүйн дэд хороо /Д.Болормаа/-нд үүрэг болгосугай.

3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны санхүүжилтийг батлагдсан төсөвт багтаан шийдвэрлэх, дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд урамшууллыг холбогдох журамд заасны дагуу тооцож олгохыг Санхүү, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны газар /Ц.Ариунсанаа/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, тус хорооны гишүүдийг чадавхжуулах ажлыг зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Ц.Гансүх/-т тус тус даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/26 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.БАЯРБАТ

